

## ТАНИЛЦУУЛГА

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай асрамжийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай

Улсын Их Хурлаас 2017 онд баталсан Ахмад настны тухай хуулийн 7.5-д “Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай асрамжийн газрыг төрөөс бодлогоор дэмжиж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх ба санхүүжүүлэх журмыг санхүүгийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасан.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/97 дугаар тушаалаар баталсан “Асрамжийн газруудын төсвийг бүрдүүлэх, зарцуулах түүнд хяналт тавих журам”, “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журам”, Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/163/247 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Зардлын норматив”-ыг улсын болон хувийн хэвшлийн байгууллагууд үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Хувийн хэвшлийн асрамжийн газрыг төрөөс бодлогоор дэмжин, Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар баталсан асруулагчийн холбогдох зардлын нормативыг улсын төсвөөс санхүүжүүлж, харин орон байр, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, ашиглалтын зардал болон ажилчдын цалинг тухайн асрамжийн газар хариуцан гаргах юм.

Ажил үйлчилгээ явуулах эрх авсан хувийн хэвшлийн асрамжийн газруудад улсын төсвөөс үзүүлж байгаа санхүүгийн дэмжлэгийг олгох, зарцуулах, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор “Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай ахмад настны асрамжийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын төслийг боловсрууллаа.

Хувийн хэвшлийн асрамжийн газарт санхүүжилтийг олгохдоо нэг асруулагчид ногдох зардлын нормативыг тухайн жилд асрамжийн газарт байнга байх асруулагчийн тоо, шинээр хүлээн авах хүнээр тооцон төлөвлөж санхүүгийн дэмжлэгийг олгоно.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

**САНГИЙН САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2017 оны.... дүгээр  
сарын ... -ны өдөр

Дугаар .....

Улаанбаатар хот

**Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай асрамжийн газарт  
санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай асрамжийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай асрамжийн газрыг санхүүжүүлэхэд шаардагдах зардлын тооцоог гарган жил бүрийн төсөвт тусгуулан санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газар /Л.Мөнхзул/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах, цаашид улс, орон нутгийн төсвөөс санхүүжиж байгаа асрамжийн газрыг журамд заасны дагуу санхүүжүүлэх боломжийг судалж үе шаттайгаар шилжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Ундрал/, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Н.Нарангэрэл/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т тус тус үүрэг болгосугай.

САНГИЙН САЙД

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

С.ЧИНЗОРИГ

Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн  
хамгааллын сайдын 2018 оны  
..... дүгээр сарын ..... -ны өдрийн  
..... дугаар хамтарсан тушаалын  
хавсралт

## **ХУВИЙН ХЭВШЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АСРАМЖИЙН ГАЗАРТ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Нийгмийн халамжийн тухай хууль, “Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” Монгол Улсын стандартыг хэрэгжүүлэн магадлан итгэмжлэгдсэн хувийн хэвшлийн байгууллагаар асрамжийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, тэдгээр байгууллагуудад санхүүгийн дэмжлэг /цаашид “санхүүжилт” гэх/ олгох, зарцуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай ахмад настны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн газар /цаашид "асрамжийн газар" гэх/-т улсын төсвөөс олгосон санхүүжилт нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5.1-д заасан төрөлжсөн асрамжийн үйлчилгээний зардлыг санхүүжүүлэхэд зарцуулагдана.

1.3. Асрамжийн газарт улсын төсвөөс олгох санхүүжилт нь асрамжийн газрын төсвийн бүрдүүлэлтийн эх үүсвэрийн нэг хэсэг байна.

### **Хоёр. Байгууллагыг сонгон шалгаруулах**

2.1. Нийгмийн халамжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасны дагуу “Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”, стандартыг хангасан иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар асрамжийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгүүлнэ.

2.2. Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.7-д заасан "Төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх, ажил үйлчилгээ явуулах эрх олгох журам"-ын дагуу магадлан итгэмжлэлд орж тэнцсэн ахмад настны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргасан байгууллагад нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр ажил, үйлчилгээ явуулах эрхийн гэрчилгээ олгох буюу сунгана.

2.3. Магадлан итгэмжлэгдэж, ажил үйлчилгээ үзүүлэх эрхийн гэрчилгээ авсан асрамжийн газар нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллана.

2.4. Хамтран ажиллах гэрээний загварыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

2.5. Асрамжийн үйлчилгээг үзүүлэх байгууллага нь тухайн орон нутгийн онцлог, хүн амын нягтрал, хэрэгцээнээс хамааран бүсчилсэн хэлбэрээр үзүүлж болно.

### **Гурав. Санхүүжилтийн хэмжээг төлөвлөх, олгох**

3.1. Асрамжийн газарт улсын төсвөөс олгох санхүүжилтийг дараах байдлаар төлөвлөнө:

3.1.1 санхүүжилтийн хэмжээг тооцож төлөвлөхдөө санхүү, төсвийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан тушаалаар баталсан төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоол, хувцас, ариун цэвэр, зөөлөн эдлэлийн зардлын дундаж норматив, асрамжийн газарт зайлшгүй байх эмийн жагсаалтыг мөрдөнө.

3.1.2. асрамжийн газар нь төсвийн дараагийн жилд байнгын асрамжийн үйлчилгээнд хамрагдах хүний тоо, нэг асруулагчид ноогдох зардлын норм, нормативийг үндэслэн шаардагдах санхүүжилтийг төлөвлөж 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

3.1.3. нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төлөвлөсөн төсвийн саналыг хянан нэгтгэж 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.1.4. нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.1.3-т заасан төсвийн хэмжээг хянаж, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт тусган санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

3.2. Асрамжийн газарт улсын төсвөөс олгох санхүүжилтийн сар, улирлын хуваарийг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь заалтын дагуу боловсруулж батална.

3.3. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу асрамжийн газруудад олгоно.

### **Дөрөв. Санхүүжилтийн зарцуулалт**

4.1. Асрамжийн газар улсын төсвөөс хуваарилсан санхүүжилтийг энэхүү журмын 1.2-т заасан санхүү, төсвийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан зардлын норматив, эд хөрөнгийн эдэлгээний хугацааны дагуу дараах үйлчилгээнд зарцуулна:

- 4.1.1. хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнс
- 4.1.2. улирлын онцлогт тохирсон 3 ээлжийн хувцас
- 4.1.3. шаардлагатай эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл
- 4.1.4. ариун цэврийн хэрэгсэл
- 4.1.5. зөөлөн эдлэл

## **Тав. Санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавих, тайлагнах**

5.1. Асрамжийн газарт олгосон санхүүжилтийн зарцуулалтад нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага тус тус хяналт тавина.

5.2. Асрамжийн газар нь үйл ажиллагаа, санхүүжилтийн зарцуулалтын тайланг улирал, хагас жилээр, асруулагчдын шилжилт хөдөлгөөний мэдээг сар бүрээр гаргаж нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

5.3. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь асрамжийн газруудын төсөв, орлого, зарлагын улирлын болон жилийн эцсийн нэгдсэн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд гаргаж санал, дүгнэлтийн хамт нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

### **Зургаа. Бусад**

6.1. Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хяналт, шалгалтаар тогтоогдсон бол хөрөнгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ..

-----ooOoo-----